

# НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн Прокурорын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/563/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер	Х.Түвшинбаяр
	Утас: 327734	Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a>
	Аудитын менежер:	С.Гантөгс
	Утас: 315558	Цахим хаяг: <a href="mailto:gantugss@audit.gov.mn">gantugss@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор:	Н.Бадамхатан
	Утас: 325093	Цахим хаяг: <a href="mailto:badamkhatann@audit.gov.mn">badamkhatann@audit.gov.mn</a>
	Аудитор: Ц.Цэнд-Аюуш	Цахим хаяг: <a href="mailto:tsend-ayushts@audit.gov.mn">tsend-ayushts@audit.gov.mn</a>
	Утас: 325093	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 216  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т  
**Өөрчлөлтгүй дүгнэлт**

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН  
ПРОКУРОРЫН ГАЗРЫН ТАМГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Ү.СОДНОМЦОГ  
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянзүрх дүүргийн Прокурорын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Баянзүрх дүүргийн Прокурорын газрын тайлант оны төсөв өмнөх оны төсвийн гүйцэтгэлээс 20.6 хувиар нэмэгдсэн нь УИХ-ын 2025 оны 24 дүгээр тогтоолоор прокуроруудын, ЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалингийн хэмжээг тус тус шинэчлэн тогтоож, нэмэгдүүлсэнтэй холбоотой байна. Нийт төсвийн 85.0 хувийг цалин хөлстэй холбоотой зардал эзэлж байна.

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

### **Аудитын гол асуудал**

Баянзүрх дүүргийн Прокурорын газарт Улсын ерөнхий прокурорын газраас цахим хурлын төхөөрөмжөөр хангаснаар цахим шүүх хурлын ерөөтэй болж, прокурорууд цаг хугацаа, орон зай харгалзахгүйгээр шүүх хуралд цахимаар оролцох нөхцөл бүрдсэн нь ажлын бүтээмжид сайнаар нөлөөлсөн байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

### **Бусад асуудал**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт дэвшүүлэн, 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, бүрэн хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>142,588,424.50</u></b>	<b><u>160,182,076.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	38,888,820.00	39,526,425.00
<b>312</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	38,888,820.00	39,526,425.00
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	38,888,820.00	39,526,425.00
31211	Төрийн сангийн харилцах	38,888,820.00	39,526,425.00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	7,796,000.00	
34600	Урьдчилж гарсан зардал	7,796,000.00	
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	95,903,604.50	120,655,651.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	95,903,604.50	120,655,651.00
35410	Бичиг хэргийн материал	988,800.00	992,500.00
35420	Аж ахуйн материал	1,328,000.00	1,554,250.00
35430	Сэлбэг хэрэгсэл	880,000.00	880,000.00
35470	Бусад хангамжийн материал	90,108,731.00	117,228,901.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>624,861,596.42</u></b>	<b><u>771,417,332.43</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	624,861,596.42	771,417,332.43
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	542,656,356.42	689,542,092.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	486,675,352.14	486,675,352.14
39202	Хуримтлагдсан элэгдэл	-201,176,674.70	-235,059,599.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	58,882,782.22	145,382,782.22
39204	Хуримтлагдсан элэгдэл	-48,132,782.10	-4,119,876.81
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	370,903,039.96	414,799,085.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-173,571,737.20	-157,295,253.07
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	88,976,330.45	88,976,330.45
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,899,954.35	-49,816,727.72
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	82,205,240.00	81,875,240.00
39301	Программ хангамж	1,320,000.00	1,320,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-330,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	80,885,240.00	80,885,240.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>767,450,020.92</u></b>	<b><u>931,599,408.43</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>38,888,820.00</u></b>	<b><u>39,526,425.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	38,888,820.00	39,526,425.00
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	38,888,820.00	39,526,425.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	38,888,820.00	39,526,425.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>728,561,200.92</u></b>	<b><u>892,072,983.43</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	728,561,200.92	892,072,983.43
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	224,952,959.19	224,952,959.19

51101	Өмч: - төрийн	224,952,959.19	224,952,959.19
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	180,885,134.93	344,396,917.44
51210	Өмнөх үеийн үр дүн	185,136,017.37	180,885,134.93
51220	Тайлант үеийн үр дүн	-4,250,882.44	163,511,782.51
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	322,723,106.80	322,723,106.80
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>767,450,020.92</u></b>	<b><u>931,599,408.43</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>5,470,051,980.50</b>	<b>6,793,130,582.15</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>58,297,180.50</b>	<b>274,650,682.15</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	58,297,180.50	274,650,682.15
<b>120017</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	24,943,717.00	274,650,682.15
<b>120018</b>	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	33,353,463.50	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,411,754,800.00</b>	<b>6,518,479,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	5,408,754,800.00	6,518,479,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,408,754,800.00	6,518,479,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>5,474,238,102.94</b>	<b>6,626,035,466.16</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,474,238,102.94</b>	<b>6,626,035,466.16</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	5,026,418,105.35	6,430,336,699.21
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	4,189,596,806.96	5,489,415,294.71
210101	Үндсэн цалин	2,433,186,766.45	3,359,925,762.79
210102	Нэмэгдэл	1,164,746,445.98	1,614,930,941.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	276,822,930.84	285,655,719.93
210104	Урамшуулал	314,840,663.69	228,902,870.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	523,919,065.74	684,125,698.60
210201	Тэтгэврийн даатгал	360,044,086.02	469,811,725.83
210202	Тэтгэмжийн даатгал	42,347,073.22	55,071,198.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,127,773.40	27,376,539.73
210204	Ажилгүйдлийн даатгал	20,071,873.36	26,309,829.48
210205	Эрүүл мэндийн даатгал	80,328,259.74	105,556,404.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,266,649.84	25,655,702.08
210301	Гэрэл, цахилгаан	12,556,401.18	15,061,453.43
210302	Түлш, халаалт	8,849,478.66	7,280,177.90
210303	Цэвэр, бохир ус	2,860,770.00	3,314,070.75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	77,155,451.87	62,648,411.16
210401	Бичиг хэрэг	34,047,320.00	36,774,800.00
210402	Тээвэр, шатахуун	6,030,000.00	6,298,073.50

**БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН  
АУДИТЫН ТАЙЛАН**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,861,801.87	3,760,173.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,890,905.00	6,923,729.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	30,325,425.00	8,891,635.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>53,911,160.00</b>	<b>4,078,850.00</b>
210604	Урсгал засвар	53,911,160.00	4,078,850.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>17,434,328.00</b>	<b>5,134,630.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,867,450.00	4,390,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	247,528.00
210807	Газрын төлбөр	497,102.00	497,102.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>140,134,642.94</b>	<b>159,278,112.66</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,147,100.00	34,766,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	117,267,542.94	124,511,612.66
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>447,819,997.59</b>	<b>195,698,766.95</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>73,596,600.00</b>	<b>100,399,542.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,156,600.00	100,199,542.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,440,000.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>374,223,397.59</b>	<b>95,299,224.95</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	374,223,397.59	95,299,224.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(4,186,122.44)</u></b>	<b><u>167,095,115.99</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>64,760.00</b>	<b>3,583,333.48</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>(64,760.00)</b>	<b>(3,583,333.48)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(4,250,882.44)</u></b>	<b><u>163,511,782.51</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>5,443,646,266.33</b>	<b>6,520,866,247.97</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>31,891,466.33</b>	<b>2,386,347.97</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	31,891,466.33	2,386,347.97
120009	Бусад орлого	31,891,466.33	2,386,347.97
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>5,411,754,800.00</b>	<b>6,518,479,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>5,408,754,800.00</b>	<b>6,518,479,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,408,754,800.00	6,518,479,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,000,000.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>5,415,580,616.33</b>	<b>6,520,228,642.97</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,415,580,616.33</b>	<b>6,520,228,642.97</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>4,964,162,828.74</b>	<b>6,324,529,876.02</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>4,201,319,833.29</b>	<b>5,491,164,037.68</b>
210101	Үндсэн цалин	2,444,909,792.78	3,361,674,505.76
210102	Нэмэгдэл	1,164,746,445.98	1,614,930,941.85
210103	Унаа хоолны хөнгөлөлт	276,822,930.84	285,655,719.93
210104	Урамшуулал	314,840,663.69	228,902,870.14
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>523,919,065.74</b>	<b>684,125,698.60</b>
210201	Тэтгэврийн даатгал	360,044,086.02	469,811,725.83
210202	Тэтгэмжийн даатгал	42,347,073.22	55,071,198.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,127,773.40	27,376,539.73
210204	Ажилгүйдлийн даатгал	20,071,873.36	26,309,829.48
210205	Эрүүл мэндийн даатгал	80,328,259.74	105,556,404.66
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>24,266,649.84</b>	<b>25,655,702.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,556,401.18	15,061,453.43
210302	Түлш, халаалт	8,849,478.66	7,280,177.90
210303	Цэвэр, бохир ус	2,860,770.00	3,314,070.75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>76,121,251.87</b>	<b>56,200,207.66</b>
210401	Бичиг хэрэг	35,090,410.00	32,644,500.00
210402	Тээвэр, шатахуун	7,088,855.00	3,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,794,396.87	3,760,173.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,890,905.00	6,923,729.66
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,256,685.00	9,171,805.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	<b>-</b>	<b>2,754,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	2,754,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>57,108,600.00</b>	<b>4,599,100.00</b>
210604	Урсгал засвар	57,108,600.00	4,599,100.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	47,954,328.00	12,401,130.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	47,387,450.00	11,656,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	69,776.00	247,528.00
210807	Газрын төлбөр	497,102.00	497,102.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	33,473,100.00	47,630,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,753,100.00	47,630,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	720,000.00	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>451,417,787.59</b>	<b>195,698,766.95</b>
213101	Бусад засгийн газрын дотоод шилжүүлэг	3,597,790.00	0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	73,596,600.00	100,399,542.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,156,600.00	100,199,542.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,440,000.00	200,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	374,223,397.59	95,299,224.95
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	374,223,397.59	95,299,224.95
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>28,065,650.00</u></b>	<b><u>637,605.00</u></b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	<u>11,495,000.00</u>	<u>0</u>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	16,570,650.00	637,605.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	22,318,170.00	38,888,820.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	38,888,820.00	39,526,425.00

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	224,952,959.19	322,723,106.80	185,136,017.37	732,812,083.36
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>224,952,959.19</b>	<b>322,723,106.80</b>	<b>185,136,017.37</b>	732,812,083.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-4,250,882.44	(4,250,882.44)
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>224,952,959.19</b>	<b>322,723,106.80</b>	<b>180,885,134.93</b>	<b>728,561,200.92</b>
D01	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>224,952,959.19</b>	<b>322,723,106.80</b>	<b>180,885,134.93</b>	<b>728,561,200.92</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>224,952,959.19</b>	<b>322,723,106.80</b>	<b>180,885,134.93</b>	<b>728,561,200.92</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	163,511,782.51	163,511,782.51
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>224,952,959.19</b>	<b>322,723,106.80</b>	<b>344,396,917.44</b>	<b>892,072,983.43</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	6,524,247,900.00	6,423,180,675.05	101,067,225.00	98%
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	6,524,247,900.00	6,423,180,675.05	101,067,225.00	98%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	6,418,080,300.00	6,322,781,133.05	95,299,167.00	99%
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	5,569,145,700.00	5,489,415,294.71	79,730,405.00	99%
210101	Үндсэн цалин	2,698,481,300.00	3,359,925,762.79	(661,444,463.00)	125%
210102	Нэмэгдэл	2,170,453,400.00	1,614,930,941.85	555,522,458.00	74%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	328,078,400.00	285,655,719.93	42,422,680.00	87%
210104	Урамшуулал	372,132,600.00	228,902,870.14	143,229,730.00	62%
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	694,883,400	684,125,699	10,757,701.00	98%
210201	Тэтгэврийн даатгал	472,682,000.00	469,811,725.83	2,870,274.00	99%
210202	Тэтгэмжийн даатгал	55,603,700.00	55,071,198.90	532,501.00	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	27,796,500.00	27,376,539.73	419,960.00	98%
210204	Ажилгүйдлийн даатгал	27,758,000.00	26,309,829.48	1,448,171.00	95%
210205	Эрүүл мэндийн даатгал	111,043,200.00	105,556,404.66	5,486,795.00	95%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,229,000.00	25,655,702.08	4,573,298.00	85%
210301	Гэрэл, цахилгаан	16,785,800.00	15,061,453.43	1,724,347.00	90%
210302	Түлш, халаалт	9,753,000.00	7,280,177.90	2,472,822.00	75%
210303	Цэвэр, бохир ус	3,690,200.00	3,314,070.75	376,129.00	90%
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	56,219,800.00	56,200,208.66	19,592.00	100%
210401	Бичиг хэрэг	30,967,600.00	32,644,500.00	(1,676,900.00)	105%
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,700,000.00	(100,000.00)	103%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,975,100.00	3,760,173.00	4,214,927.00	47%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,796,100.00	6,923,729.66	(5,127,630.00)	385%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,881,000.00	9,171,805.00	2,709,195.00	77%
2105	<b>Норматив зардал</b>	2,754,000.00	2,754,000.00	-	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,754,000.00	2,754,000.00	-	
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,602,600.00	4,599,100.00	3,500.00	100%
210604	Урсгал засвар	4,602,600.00	4,599,100.00	3,500.00	100%
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,401,800.00	12,401,130.00	670.00	100%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,656,700.00	11,656,500.00	200.00	100%

210804	Тээврийн хэрэгслийн татвар	247,600.00	247,528.00	72.00	100%
210807	Газрын төлбөр	497,500.00	497,102.00	398.00	100%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>47,844,000.00</b>	<b>47,630,000.00</b>	<b>214,000.00</b>	<b>100%</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,844,000.00	47,630,000.00	214,000.00	100%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>106,167,600.00</b>	<b>100,399,542.00</b>	<b>5,768,058.00</b>	<b>95%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>106,167,600.00</b>	<b>100,399,542.00</b>	<b>5,768,058.00</b>	<b>95%</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	100,199,600.00	100,199,542.00	5800.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,968,000.00	200,000.00	5,768,000.00	3%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>6,524,247,900.00</b>	<b>6,423,180,675.05</b>	<b>101,067,225.00</b>	<b>98%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>6,524,247,900.00</b>	<b>6,423,180,675.05</b>	<b>101,067,225.00</b>	<b>98%</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	6,524,247,900.00	6,423,180,675.05	101,067,225.00	98%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>83</b>	<b>75</b>	<b>8</b>	<b>90%</b>
620001	Удирдах ажилтан	1	1	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	68	60	8	88%
620003	Үйлчлэх ажилтан	14	14	-	100%

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Бараа материалын баримтаас түүвэрлэж үзэхэд анхан шатны баримтын бүрдэл дутуу гүйлгээ хийсэн байна.	1	4,949.1					1	4,949.1				
Дүн	1	4,949.1					1	4,949.1				